| Бэлэн бүтээгдэхүүн | 5,330.7 | 6,044.0 | 713.3 | 4.5 |
| Хангамжийн материал | 22,209.8 | 26,537.2 | 4,327.4 | 19.8 |
| Мал амьтад | 169.9 | 185.3 | 15.4 | 0.1 |
| **Дүн** | **64,335.2** | **133,896.5** | **69,561.3** | **100.0** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Коронавируст халдвар (Covid-19) тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, онцгой нөхцөлийн бэлэн байдлыг хангахад зориулж олон улсын байгууллага, иргэд, аж ахуйн нэгжээс өгсөн хандив тусламж, Засгийн газрын нөөц хөрөнгөөс худалдан авсан түргэвчилсэн оношлуур, урвалж, хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис, эм эмнэлгийн хэрэгслийн нөөц үүсгэсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Бараа материалын данстай холбоотой нийт 4,597.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Тухайлбал:*

- *Бараа материалын худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, шууд зардлаар тайлагнасан 3,282.9 сая төгрөгийн зөрчил; /Нийслэлийн түргэн тусламжийн төв 1,424.8 сая, Ховд аймгийн БОЭТ 504.2 сая, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 272.8 сая, Шүд эрүү нүүрний төв 228.1 сая, Уламжлалт анагаах*

*ухааны элэг судлалын клиник төв 186.2 сая, Цус сэлбэлт судлалын үндэсний төв 173.1 сая, СХД-ийн эрүү мэндийн газар 102.8 сая/*

- *Бараа материалын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тодруулга тайлан, орлого, зарлагын журналаас зөрүүтэй 1,474.4 сая төгрөгийн зөрчил; /Өмнөговь аймгийн ЭМГ 744.4 сая, Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг 521.5 сая, Баян-Өлгийн аймгийн Дэлүүн сум дундын эмнэлэг 68.6 сая, Баянхонгор аймгийн ЭМГ 54.1 сая, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум дундын эмнэлэг 39.4 сая/*
- *Автомашины 100 километрт зарцуулах шатахууны норм, нормативыг хэтрүүлсэн, шатахууны тооцоо хийгээгүй, тайлан гаргаагүй зэрэг 234.1 сая төгрөгийн зөрчил; /Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг 46.1 сая, Ховд аймгийн Мөст сум дундын эмнэлэг 25.1 сая, ХУД-ийн эрүүл мэндийн төв ЭМТ 20.2 сая, Өвөрхангай аймгийн ЭМГ 16.2 сая, Хүүхдийн төв сувилал 13.2 сая/*
- *Бараа материалын ангиллыг буруу бүртгэсэн, нөөц үүсгэсэн, зориулалт бусаар зарцуулсан 229.0 сая төгрөгийн зөрчил; /Ховд аймгийн БОЭТ 77.5 сая, Нийслэлийн түргэн тусламжийн төв 38.6 сая, Ховд аймгийн ЭМГ 24.5 сая, Хавдар судлалын үндэсний төв 21.1 сая, Дундговь аймгийн Уламжлалт анагаах ухааны төв 14.1 сая/*

### 3.5.3 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 301,381.6 сая, эцсийн үлдэгдэл 405,622.1 сая төгрөг болж, 104,240.5 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын 133 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс шалтгаалсан байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 825,108.4 сая, эцсийн үлдэгдэл 912,196.1 сая төгрөг болж, 87,087.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Барилга, байгууламж, орон сууц | 542,342.7 | 575,814.7 | 33,472.0 | 63.1 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 11,317.3 | 14,029.9 | 2,712.6 | 1.5 |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 199,535.6 | 249,280.3 | 49,744.7 | 27.3 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,393.8 | 18,090.3 | 3,696.5 | 2.0 |
| Зам, гүүрийн байгууламж | 191.6 | 1,542.4 | 1,350.8 | 0.2 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 6.0 | 6.0 | - | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 3,215.7 | 3,144.2 | (71.5) | 0.3 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 4,726.0 | 621.9 | (4,104.1) | 0.1 |
| Ном | 212.7 | 37.3 | (175.4) | 0.0 |
| Программ хангамж | 1,333.9 | 1,290.0 | (43.9) | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 47,833.1 | 48,339.1 | 506.0 | 5.3 |
| **Дүн** | **825,108.4** | **912,196.1** | **87,087.7** | **100.0** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 16,076.4 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 25,062.7 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 138,236.0 сая, дахин үнэлгээний нэмэгдлээр 105.4 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 67.4 сая, балансаас балансад шилжүүлсэн 16,866.1 сая, акталсан 30,465.4 сая, дахин үнэлгээний хорогдол 1,776.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд холбогдох байгууллагуудад нь шилжүүлээгүй Амгалан амаржих газрын 547.8 сая төгрөгийн цахилгааны болон холбооны барилга байгууламж 2016 оноос хойш бүртгэлтэй байна.

Япон улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2019 онд ашиглалтад орсон АШУҮИС-ын Монгол-Японы эмнэлгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилган аудитын явцад Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021 оны 83 дугаар тогтоол, эмнэлгийн захирлын 2021 оны А/63 дугаар тушаалаар 166,036.1 сая төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 17,376.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал,*

- *Төрийн өмчийн хөрөнгийг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаагүй 4,211.1 сая төгрөгийн зөрчил; /Эрүүл мэндийн яам 4,141.6 сая, Гэмтэл, согог судлалын үндэсний төв 37.9 сая, Эрүүл мэндийн хөгжлийн төв 31.6 сая/*
- *Төсвийн хуваарьт өөрчлөлт хийлгүй хөрөнгө худалдан авсан, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй 4,129.5 сая төгрөгийн зөрчил; /СБД-ийн нэгдсэн эмнэлэг 2,219.6 сая, Халдварт өвчин судлалын үндэсний төв 960.4 сая, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 403.8 сая, Нийслэлийн ЭМГ 187.6 сая, СБД-ийн эрүүл мэндийн газар 128 сая, Багахангай дүүргийн ЭМТ 104.0 сая/*
- *Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн актлаагүй, хөрөнгийн элэгдлийг буруу тооцож бүртгэсэн, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй 3,414.2 сая төгрөгийн зөрчил; /Дархан аймгийн нэгдсэн эмнэлэг 2,323.5 сая, Гэмтэл, согог судлалын үндэсний төв 457.7 сая, СХД-ийн нэгдсэн эмнэлэг 346.7 сая, Өмнөговь аймгийн ЭМГ 83.3 сая, Архангай аймгийн Тариат сум дундын эмнэлэг 81.6 сая/*
- *Хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн, хөрөнгө биетээр оршин байхгүй, данс бүртгэлд тусгаагүй 3,244.2 сая төгрөгийн зөрчил; /Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв 2,833.0 сая, Багахангай дүүргийн ЭМТ 185.3 сая, Булган аймгийн Хишиг-Өндөр сум дундын эмнэлэг 46.7 сая, Шүд, эрүү, нүүрний төв 46.0 сая, Булган аймгийн нэгдсэн эмнэлэг 39.2 сая/*
- *ТӨБЗГ болон орон нутгийн өмчийн газраас зохих зөвшөөрөл аваагүй, урсгал зардлын төсвөөс хөрөнгө худалдан авсан 2,374.3 сая төгрөгийн зөрчил; /Эрүүл мэндийн яам 1,749.7 сая, Улсын хоёрдугаар төв эмнэлэг 278.3 сая, Налайх дүүргийн ЭМГ 142.6 сая, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг 74.9 сая, Дорнод аймгийн Баян-уул сум дундын эмнэлэг 62.9 сая, Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг 28.0 сая/*

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 30,665.3 сая, эцсийн үлдэгдэл 25,405.9 сая төгрөг болж, 5,259.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 244.1 | 976.6 | 732.5 | 3.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 734.4 | 467.3 | (267.1) | 1.8 |
| Бусад өглөг | 28,061.1 | 22,450.1 | (5,611.0) | 88.4 |
| Урьдчилж орсон орлого | 1,625.7 | 1,511.9 | (113.8) | 6.0 |
| **Дүн** | **30,665.3** | **25,405.9** | **(5,259.4)** | **100.0** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 18,038.2 сая төгрөгийн барьцаа, байгууллагад төлөх 4,411.9 сая, ажилчидтай холбогдсон 976.6 сая, бараа үйлчилгээний зардлын 467.3 сая төгрөгийн өр, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн 1,458.7 сая, Цус сэлбэлт судлалын

үндэсний төвийн 36.0 сая, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 17.2 сая төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Өр төлбөрийн данстай холбоотой нийт 2,020.2 сая төгрөгийн зөрчил байна. Үүнд:*

- *Өмнөх оны санхүүгийн тайланд тусгаагүй 86.6 сая төгрөгийн өр төлбөрийг тайлант онд төлж барагдуулсан; /Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг 83.3 сая, ХУД-ийн 4 дүгээр клиник сувилал 3.3 сая, Сэлэнгэ аймгийн ЭМГ 0.5 сая/*
- *Тайлант онд 360.3 сая төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /Эх хүүхдийн эрүүл мэндийн төв 359.7 сая, ХУД-ийн эрүүл мэндийн төв 0.6 сая/;*
- *Өр төлбөрийг барагдуулаагүй, шинээр өр төлбөр үүсгэсэн; /Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв 755.2 сая, Халдварт өвчин судлалын үндэсний төв 668.9 сая, Өргөө амаржих газар 133.8 сая, Өмнөговь аймгийн ЭМГ 8.4 сая, Өмнөговь аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 3.6 сая, Булган аймгийн ЭМГ 2.9 сая/*

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,193,180.9 сая, эцсийн үлдэгдэл 1,476,795.4 сая төгрөг болж, 283,614.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 368,888.3 | 369,628.4 | 740.1 | 25.0 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 301.8 | 301.8 | - | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 473,926.0 | 756,805.7 | 282,879.7 | 51.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 350,064.8 | 350,059.5 | (5.3) | 23.7 |
| **Дүн** | **1,193,180.9** | **1,476,795.4** | **283,614.5** | **100.0** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь эргэлтийн хөрөнгийн дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 756,805.7 сая төгрөг болж 282,879.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд тусламж, санхүүжилтийн орлого нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлтийн алдааны залруулга дансанд дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан, БШУС-ын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1а/9887 дугаар албан бичгийг үндэслэн Улаанбаатар хотын 40, 41 дүгээр ясли, 4 дүгээр клиник сувилал Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, бүртгэсэн 2,576.1 сая төгрөгийн алдааны залруулга байна.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 964,554.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголоор урсгал зардлыг 107,894.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн зардлыг 13,804.1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 1,058,645.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 938,693.2 сая төгрөгийг урсгал зардалд, 119,952.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 778,278.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 252,908.7 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 27,458.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 761,771.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 199,784.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, нийт 961,555.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны 25,348.4 сая төгрөгийн орлого олж, батлагдсан төсөв 2,110.2 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдалд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч, үйлчлүүлэгч, амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний тоо буурснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 986,905.6 сая төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь төрийн өмчит байгууллагад олгох татаас 66.6 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 74.6 хувьтай байгаагаас шалтгаалсан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод эмнэлгийн тусламж үйлчилгээ нь “Үйлчлүүлэгч төвтэй” байж, тусламж үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан, бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг хэрэгжүүлэх гэсэн шаардлагын дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Арьсны өвчин судлалын үндэсний төвийг 2020 оноос эхлэн Төрийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг болгон өөрчилж гүйцэтгэлээр санхүүжилт олгодог болсноор төрийн өмчит байгууллагад олгох татаас 29,914.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Коронавируст халдвар (Covid-19) цар тахлын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдийн өндөр өртөгт мэс заслын эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас шалтгаалан бараа, үйлчилгээний зардал буурсан байна.

Хөрөнгө оруулалтын 133 төсөл, арга хэмжээнд 119,952.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 108,158.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 15,375.5 сая төгрөгийг барьцаа дансанд, 54.4 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 12,439,8 сая, Засгийн газрын нөөц сангаас 29,834,6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 27,145.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,217.0 сая, нийт 79,636.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 56,092.7 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 4,744.5 сая, хөрөнгийн зардалд 510.6 сая, нийт 61,347.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 18,288.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Коронавируст халдвар (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивын судалгаагаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 145 байгууллагуудад нийт 1,260.8 сая төгрөгийн мөнгөн, 27,395.4 сая төгрөгийн мөнгөн бус хандивыг иргэд, аж ахуйн нэгжээс тайлант онд өгсөн байна.

Засгийн газрын нөөц сангаас Коронавируст халдварт (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэхэд зориулж Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад олгосон 29,834.6 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 15,000.0 сая төгрөгийг татаас санхүүжилтийг авлагаар тайлагнасан.

Төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 чиглэлийн 17 ажлаас эхийн эндэгдлийн харьцаа (100,000 амьд төрөлтөд), хорт хавдар өвчний шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүн амд ногдох), Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь, чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо, гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо зорилтод түвшинд хүрээгүй байна.

Энэ нь Коронавируст халдвар (Covid-19) цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр иргэдийн хөдөлгөөн хязгаарлагдаж эрт илрүүлгийн хамралтын хувь буурсан, жирэмсэнтэй хавсарсан эмгэгийн шалтгаант эхийн эндэгдэл нэмэгдсэн, чихрийн шижин өвчний хамралтын хувь тооцох насны ангилал, аргачлалд өөрчлөлт оруулсан, гадаад орноос тогтоосон хөл хорио, хилийн хязгаарлалттай холбоотойгоор гадаадад мэргэжилтнүүд суралцаагүй зэргээс шалтгаалсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2011-2013 онуудад хэрэгжиж эхэлсэн олон жилийн насжилттай 70,712.0 сая төгрөгийн 8 барилга байгууламж бүртгэлтэй байгаа нь барилгын төсөвт өртөг нэмэгдэх, төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Коронавируст халдвар (Covid-19) цар тахлын эрсдэлээс хүн амыг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж олгосон санхүүжилтийн урьдчилгаа 2,423.8 сая, байгууллагаас авах авлага 8,841.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хуваарьт тайлант оны эцэст зохицуулалт хийн эрх шилжүүлж, харьяа байгууллагууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь тэдгээрийн санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагаанд хүндрэл учруулах, холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байх, авлага үүсэх нөхцөлийг бий болгож төсвийн төлөвлөлт бодитой хийгдэхгүй байгааг харуулж байна.

### 3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагч тайлант хугацаанд 139 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 102 мэдээлэл, хугацаа хоцроож 37 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 6,827.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 4 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн 212.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох ангиллын дагуу залруулан бүртгэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, харьяа 26 байгууллага 37.3 сая төгрөгийн хөрөнгийг залруулж бүртгээгүй байна.

*Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 6,827.1 | 3 | 6,789.8 | 99.5 |
| **Нийт дүн** | **5** | **6,827.1** | **4** | **6,789.8** | **99.7** |

### 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Коронавируст халдвар (Covid-19) цар тахлын эрсдэлээс хүн амыг хамгаалахад зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн байгаа хандив, тусламжийг холбогдох хууль журмын дагуу бүртгэж тайлагнах, бараа материал, тоног төхөөрөмжийг сайдын тушаал шийдвэрийг үндэслэн хуваарилах, хоорондын тооцоог тухай бүр үүсгэж, тооцоо нийлж байгаа эсэхийг дараагийн аудитад анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 180 тайлан нэгтгэснээс тусгай зориулалтын шилжүүлгийн 22, бие даан дүгнэлт гаргасан 145 тайлан /Зөрчилгүй 117, Хязгаарлалттай 21, Сөрөг 6, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1/ хамрагдаж, итгэл үзүүлсэн 8, аудитын түвшинд хамрагдсан 1, аудитад хамрагдаагүй 4 тайлан байна.

### 4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 48,877.1 сая төгрөгийн 150 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 58,453.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 267.5 сая төгрөгийн зөрчилд 89 төлбөрийн акт тогтоож, 24,518.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 210 албан шаардлага хүргүүлж, 33,667.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 332 зөвлөмж өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 6 байгууллагад “Сөрөг” дүгнэлт /Эрүүл мэндийн яам, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг, Булган аймгийн Хишиг-Өндөр сум дундын эмнэлэг/, 1 байгууллагад “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” /АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг/ дүгнэлтийг тус тус өгсөн байна.

### 4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 261,684.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,383.2 сая төгрөгийн алдааг залруулж, 124,136.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 129,165.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд Эрүүл мэндийн яамнаас харьяа байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн 8,362.5 сая төгрөгийн бараа материалын хоорондын тооцоог дутуу, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн хоорондын тооцоог 20.7 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

**Албан шаардлага**

1. Өмнөх оны аудитаар өгсөн 212.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох ангиллын дагуу залруулан бүртгэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, харьяа 26 байгууллага 37.3 сая төгрөгийн хөрөнгийг залруулж бүртгээгүй байгаа нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөх.
2. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Эрүүл мэндийн яам, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг, Булган аймгийн Хишиг-Өндөр сум дундын эмнэлэг зэрэг 6 байгууллага “Сөрөг” дүгнэлт, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг “Дүгнэлт өгөхөөс татгалзах” дүгнэлт авсан байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “... санхүүгийн тайлангийн

аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2-т "төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг үндэслэн холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авах.

3. ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах (MON-8) төслийн 124,098.7 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын тушаал шийдвэргүй Улсын хоёрдугаар төв эмнэлэгт шилжүүлж ашиглуулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй байгаа нь ТӨБЗГ-ын даргын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байгаад зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

***1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2011-2013 онуудад хэрэгжиж эхэлсэн олон жилийн насжилттай 70,712.0 сая төгрөгийн 8 дуусаагүй барилга, байгууламж бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга ба тодруулга", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн төслийг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, царцаагдсан барилгыг ашиглалтад оруулах асуудлыг холбогдох газар тавьж шийдвэрлүүлэх.

***2. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 107,330.2 сая төгрөгийн 781 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 48,877.1 сая төгрөгийн 150 алдааг залруулж, 267.5 сая төгрөгийн 89 төлбөрийн акт, 24,518.5 сая төгрөгийн 210 албан шаардлага, 33,667.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 332 зөвлөмж хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах, зөвлөгөө арга зүйгээр хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Харьяа байгууллагууд | Итгэл үзүүлсэн | Түүвэрт | Дүгнэлтийн хэлбэр | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн ерөнхийлөн захирагч | | | | | | | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн сайд | | | | 1 | | | | | 3 | 124,136.0 | 2 | 129,165.1 |
| | **ДҮН** | | | | **1** | | | | | **3** | **124,136.0** | **2** | **129,165.1** |
| Засгийн газрын тусгай сан | | | | | | | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийг дэмжих сан | | | 1 | | | | | | 2 | | | |
| | **ДҮН** | | | **1** | | | | | **-** | **2** | **-** | **-** | **-** |
| Төсөл хөтөлбөр | | | | | | | | | | | | | |
| 1 | Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төсөл | | | 1 | | | | | | 1 | - | 2 | 35.0 |
| 2 | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-н төсөл | | | 1 | | | | | | 1 | | 2 | 40.9 |
| 3 | Вируст гепатитын урьдчилан сэргийлэлт илрүүлэлтийг сайжруулах төсөл | | | | | | | | | | | | |
| 4 | Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө боловсруулах төсөл | | | | | | | | | | | | |
| | **ДҮН** | | | **2** | | | | | **-** | **2** | **-** | **4** | **75.9** |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | | | | | | | | | | | | | |
| 1 | Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв | | | 1 | | | | 1 | 0.3 | 2 | 1.2 | 1 | - |
| 2 | Биотехнологи үйлдвэр судалгааны төв | | | | | | | | | | | | |
| | **ДҮН** | | | **1** | | | | **1** | **0.3** | **2** | **1.2** | **1** | **-** |
| Төсвийн шууд захирагч | | | | | | | | | | | | | |
| 1 | АШУҮИС-ийн Монгол-Япон эмнэлэг | | | | | | 1 | | | | | | |
| 2 | Амгалан амаржих газар | | | 1 | | | | | | 3 | 13.9 | 3 | 1.3 |
| 3 | Архангай Зооноз өвчин судлалын төв | 1 | | | | | | | | | | | |
| 4 | Архангай Эрүүл мэндийн газар | | | 1 | | | | | | 1 | 5.9 | 1 | 16.2 |
| 5 | Архангай Нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | | | 2 | 2.9 |
| 6 | Ар Тариат СДЭ | | | 1 | | | | | | 1 | 17.2 | 4 | 85.0 |
| 7 | Архангай Эрдэнэмандал СДЭ | | | 1 | | | | 1 | 6.7 | 1 | | 2 | |
| 8 | Арьсны өвчин судлалын үндэсний төв | | | 1 | | | | 2 | 0.6 | 1 | | 2 | 11.7 |
| 9 | Багахангай ЭМГ | | | | 1 | | | | | 2 | | 4 | 312.0 |
| 10 | Баянгол ЭМГ | | | | 1 | | | | | 3 | 350.2 | 7 | 205.8 |
| 11 | Баянзүрх ЭМГ | | | 1 | | | | 2 | 12.8 | | | 1 | 5.5 |
| 12 | Багануур ЭМГ | | | 1 | | | | 1 | 0.7 | 2 | 21.1 | 2 | 3.2 |
| 13 | Баян-Өлгий Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | | | 1 | - |
| 14 | Баян-Өлгий Дэлүүн СДЭ | | | | 1 | | | 1 | 1.0 | 1 | 68.6 | 1 | |
| 15 | Баян-өлгий Ногооннуур СДЭ | | | 1 | | | | | | | | 2 | 63.1 |
| 16 | Баян-Өлгий Цэнгэл СДЭ | | | 1 | | | | | | | | 2 | 11.3 |
| 17 | Баян-Өлгий нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | 1 | 597.5 | 1 | 266.6 |
| 18 | Баян-Өлгий ЭМГ | 1 | | | | | | | | | | | |
| 19 | Булган ЭМГ | | | 1 | | | | 2 | 6.1 | | | 4 | 7.9 |
| 20 | Булган нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 3 | 0.9 | | | 4 | 154.6 |
| 21 | Булган Хишиг-Өндөр СДЭ | | | | | 1 | | | | 4 | 116.5 | 7 | 37.6 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | Булган Хутаг-Өндөр ЭМТ | | | 1 | | | | 2 | 0.1 | 1 | 5.4 | 4 | 7.4 |
| 23 | Баянхонгор Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | 2 | 1.9 | | | 3 | 0.3 |
| 24 | Баянхонгор Богд СДЭ | | | 1 | | | | | | | | 3 | 2.7 |
| 25 | Баянхонгор ЭМГ | | | 1 | | | | 2 | 3.9 | 2 | 54.7 | 2 | 1.6 |
| 26 | Баянхонгор Баянцагаан СДЭ | | | 1 | | | | | | 1 | | | |
| 27 | Баянхонгор Жаргалант СДЭ | | | 1 | | | | | | 1 | 1.6 | 2 | |
| 28 | Баянхонгор нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 3.1 | 2 | 10.7 | 4 | 1.7 |
| 29 | Геронтологийн үндэсний төв | | | | 1 | | | | | 1 | | 6 | 105.8 |
| 30 | Говь-Алтай ЭМГ | | | 1 | | | | 5 | 1.6 | | | 4 | 3.2 |
| 31 | Говь-Алтай нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 4 | 4.0 | 7 | 42.9 | 2 | 23.0 |
| 32 | Говь-Алтай Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | 1 | 0.2 | 3 | 4.3 | 1 | 0.8 |
| 33 | Говь-Алтай Уламжлалт анагаах ухааны төв | | | 1 | | | | 4 | 1.4 | 3 | 33.8 | 1 | 4.0 |
| 34 | Говь-Алтай Бигэр сумын ЭМТ | | | 1 | | | | 3 | 0.5 | 4 | 18.0 | 2 | 2.4 |
| 35 | Говь-Алтай Төгрөг сумын ЭМТ | | | 1 | | | | 2 | 0.4 | 1 | | | |
| 36 | Говь-Алтай Баян-Уул сумын ЭМТ | | | 1 | | | | 3 | 2.0 | 4 | 7.9 | 1 | 3.0 |
| 37 | Говьсүмбэр ЭМГ | | | 1 | | | | | | 1 | | 1 | |
| 38 | Говьсүмбэр нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 0.7 | 1 | 2.6 | 4 | 0.2 |
| 39 | Гэмтэл согог судлалын үндэсний төв | | | | 1 | | | 1 | 2.0 | 3 | 38.8 | 6 | 656.3 |
| 40 | Дархан ЭМГ | | | 1 | | | | | | | | 3 | 121.5 |
| 41 | Дархан нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | | | 4 | 2,327.1 |
| 42 | Дорнод БОЭТ | | | 1 | | | | | | 4 | 103.9 | | |
| 43 | Дорнод Уламжлалт анагаах ухааны төв | | | 1 | | | | | | 1 | 0.9 | 1 | 32.6 |
| 44 | Дорнод Халх гол сумын ЭМТ | | | 1 | | | | | | 1 | 101.4 | | |
| 45 | Дорнод ЭМГ | | | 1 | | | | | | 1 | 1,482.8 | | |
| 46 | Дорнод Баян-Уул СДЭ | | | 1 | | | | | | 3 | 71.6 | | |
| 47 | Дорнод Дашбалбар СДЭ | | | 1 | | | | | | 2 | 67.2 | 2 | 12.2 |
| 48 | Дорноговь нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | 1 | 12.3 | 5 | 86.9 |
| 49 | Дорноговь Замын үүд СДЭ | | | 1 | | | | | | | | 5 | 0.6 |
| 50 | Дорноговь Зүүнбаян СДЭ | | | 1 | | | | | | | | 2 | |
| 51 | Дорноговь Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв | | | 1 | | | | | | | | 3 | 1.8 |
| 52 | Дорноговь Халзан уул рашаан сувиллын төв | | | 1 | | | | | | | | 5 | 1.5 |
| 53 | Дорноговь ЭМГ | | | 1 | | | | | | 2 | 5.0 | 1 | |
| 54 | Дундговь ЭМГ | | | 1 | | | | | | 1 | | | |
| 55 | Дундговь Уламжлалт анагаах ухааны төв | | | 1 | | | | 1 | 0.3 | 1 | 14.1 | | |
| 56 | Дундговь Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | 3 | 0.4 | | |
| 57 | Дундговь Эрдэнэдалай СДЭ | | | 1 | | | | | | 1 | | | |
| 58 | Дундговь нэгдсэн эмнэлэг | 1 | | | | | | | | | | | |
| 59 | Дундговь Говь-угтаал СДЭ | | | 1 | | | | | | 1 | 2.7 | | |
| 60 | Завхан ЭМГ | 1 | | | | | | | | | | | |
| 61 | Завхан нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 0.9 | | | 3 | 15.4 |
| 62 | Завхан Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | 1 | 2.2 | | | 1 | 0.5 |
| 63 | Завхан Тосонцэнгэл СДЭ | | | 1 | | | | 1 | 1.7 | | | | |
| 64 | Завхан Түдэвтэй СДЭ | | | 1 | | | | | | | | 2 | 0.8 |
| 65 | Завхан Шилүүстэй СДЭ | | | 1 | | | | | | | | 1 | |
| 66 | Завхан Завханмандал СДЭ | 1 | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | Завхан Отгонтэнгэр Рашаан сувилал | | | | 1 | | | 1 | 10.8 | 2 | 21.6 | | |
| 68 | Зоонозын өвчин судлалын үндэсний төв | | | 1 | | | | | | 1 | | 2 | |
| 69 | Налайх ЭМГ | | | 1 | | | | 1 | 0.6 | 2 | 35.3 | 4 | 142.6 |
| 70 | Наркологийн эмнэлэг | | | | 1 | | | | | 1 | 33.3 | 2 | 48.2 |
| 71 | Нийслэлийн ЭМГ | | | 1 | | | | | | 2 | 187.6 | 3 | 73.4 |
| 72 | Орхон ЭМГ | | | | 1 | | | 1 | 0.1 | 2 | 4,740.5 | 4 | 6.4 |
| 73 | Орхон нэгдсэн эмнэлэг /Бүсийн оношилгоо/ | | | 1 | | | | 1 | 0.6 | 2 | 27.4 | 2 | 45.3 |
| 74 | Өвөрхангай ЭМГ | | | 1 | | | | | | 4 | 478.2 | | |
| 75 | Өвөрхангай БОЭТ | | | 1 | | | | | | 2 | 56.0 | | |
| 76 | Өвөрхангай Хар-хорин СДЭ | | | 1 | | | | | | 3 | 136.0 | | |
| 77 | Өвөрхангай Есөнзүйл СДЭ | | | | 1 | | | | | 4 | 70.9 | 1 | |
| 78 | Өмнөговь ЭМГ | | | | 1 | | | | | 6 | 704.7 | 3 | 179.7 |
| 79 | Өмнөговь Ноён СДЭ | | | 1 | | | | | | 1 | | 1 | |
| 80 | Өмнөговь Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | 1 | 7.6 | 2 | 3.1 |
| 81 | Өмнөговь нэгдсэн эмнэлэг /Бүсийн оношилгоо/ | | | 1 | | | | 1 | 2.6 | 2 | | | |
| 82 | Өмнөговь Ханбогд СДЭ | 1 | | | | | | | | | | | |
| 83 | Өмнөговь Цогтцэций СДЭ | | | 1 | | | | | | | | | |
| 84 | Өргөө амаржих газар | | | | 1 | | | | | | | 2 | 428.3 |
| 85 | СБД-ийн нэгдсэн эмнэлэг | | | | | 1 | | | | 7 | 2,226.7 | 3 | |
| 86 | СБД-ийн ЭМГ | | | | 1 | | | | | 2 | 148.7 | 4 | 5.2 |
| 87 | Сүхбаатар Онгон СДЭ | | | 1 | | | | | | 1 | | | |
| 88 | Сүхбаатар аймаг нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 2 | 27.4 | 2 | 28.0 | | |
| 89 | Сүхбаатар аймаг ЭМГ | | | 1 | | | | 5 | 6.8 | 5 | 209.9 | | |
| 90 | СХД-ийн нэгдсэн эмнэлэг | | | | 1 | | | | | 2 | 101.4 | 2 | 346.7 |
| 91 | СХД-ийн ЭМГ | | | 1 | | | | | | 1 | 102.8 | 2 | 68.3 |
| 92 | Сэлэнгэ ЭМГ | | | 1 | | | | | | 2 | 33.5 | 3 | |
| 93 | Сэлэнгэ нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 1.3 | 1 | 6.3 | 3 | 58.5 |
| 94 | Сэлэнгэ Мандал СДЭ | | | 1 | | | | 2 | 0.9 | 2 | 42.1 | 4 | 5.2 |
| 95 | Сэлэнгэ Сайхан сум СДЭ | | | 1 | | | | 1 | 0.2 | 1 | 2.2 | | |
| 96 | Сэлэнгэ Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | 1 | 0.8 | | | 2 | 7.1 |
| 97 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | | | 1 | | | | | | | | 2 | 12.6 |
| 98 | Төв ЭМГ | | | 1 | | | | 1 | 0.4 | 2 | 8.7 | 2 | 66.8 |
| 99 | Төв нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | 3 | 49.8 | 3 | 28.5 |
| 100 | Түргэн тусламжийн төв | | | | | 1 | | 2 | 14.6 | 5 | 696.6 | 9 | 886.4 |
| 101 | Улаанбаатар БЗД 40-р ясли -Бяцхан тэмүүлэл төв | | | 1 | | | | | | 1 | | 3 | 32.2 |
| 102 | Улаанбаатар Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | 1 | 0.3 | 2 | 2.2 |
| 103 | Улаанбаатар СХД 41-р ясли | | | 1 | | | | | | | | 3 | 1.9 |
| 104 | Улаанбаатар ХУД 4-р клиник сувилал | | | 1 | | | | | | | | 4 | 13.0 |
| 105 | Увс Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | | | | |
| 106 | Увс ЭМГ | | | 1 | | | | | | | | | |
| 107 | Увс нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 1.5 | | | | |
| 108 | Увс Баруунтуруун ЭМТ | | | 1 | | | | | | | | | |
| 109 | Увс Өмнөговь ЭМТ | | | 1 | | | | | | | | | |
| 110 | Увс Өндөрхангай ЭМТ | | | | 1 | | | 1 | 3.3 | 2 | 4.5 | | |
| 111 | Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн | | | 1 | | | | | | | | 5 | 96.2 |
| 112 | Уламжлал анагаах ухааны элэг судлалын клиник төв | | | | | 1 | | | | 4 | 3,800.5 | | |
| 113 | Улсын Нэгдүгээр төв эмнэлэг | | | | 1 | | | 1 | 0.5 | 1 | 209.6 | 6 | 500.9 |
| 114 | Улсын Гуравдугаар төв эмнэлэг | | | 1 | | | | 2 | 84.7 | 1 | 48.0 | 6 | 352.7 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 115 | Улсын Хоёрдугаар төв эмнэлэг | | | | 1 | | | 1 | 5.1 | 3 | 1,223.4 | 2 | 10.1 |
| 116 | Хавдар судлалын үндэсний төв | | | 1 | | | | | | | | 6 | 145.6 |
| 117 | Халдварт өвчин судлалын үндэсний төв | | | | 1 | | | | | 4 | 2,384.8 | 2 | 1,607.5 |
| 118 | Ховд Булган нэгдсэн эмнэлэг | | | | | 1 | | 3 | 30.5 | 3 | 521.5 | 7 | 207.5 |
| 119 | Ховд БОЭТ | | | 1 | | | | 1 | 3.7 | 5 | 544.7 | 2 | 77.5 |
| 120 | Ховд Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | | | 2 | 7.6 |
| 121 | Ховд Мөст СДЭ | | | | 1 | | | 1 | 2.3 | 1 | 25.1 | 4 | 16.8 |
| 122 | Ховд ЭМГ | | | 1 | | | | | | | | 2 | 24.5 |
| 123 | Хөвсгөл ЭМГ | | | 1 | | | | | | | | 3 | |
| 124 | Хөвсгөл нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | | | 3 | |
| 125 | Хөвсгөл Их-уул СДЭ | 1 | | | | | | | | | | 1 | |
| 126 | Хөвсгөл Хатгал СДЭ | | | 1 | | | | | | | | | |
| 127 | Хөвсгөл Цагаан Уул СДЭ | | | 1 | | | | | | | | | |
| 128 | Хөвсгөл Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | | | 2 | |
| 129 | Хөвсгөл Улаан уул СДЭ | | | 1 | | | | | | | | | |
| 130 | Хөвсгөл Шинэ идэр СДЭ | 1 | | | | | | | | | | | |
| 131 | ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | | | 4 | 4.6 |
| 132 | ХУД-ийн ЭМГ | | | 1 | | | | 2 | 5.2 | 2 | 110.0 | 5 | 33.3 |
| 133 | Хүрээ амаржих газар | | | 1 | | | | | | | | 2 | 23.5 |
| 134 | Хүүхдийн төв сувилал | | | 1 | | | | | | 1 | | 5 | 30.5 |
| 135 | Хэнтий ЭМГ | | | 1 | | | | 1 | 1.1 | 2 | 14.4 | 2 | 1,887.3 |
| 136 | Хэнтий нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 1.1 | 1 | 24.6 | 1 | |
| 137 | Хэнтий Бэрх эрүүл мэндийн төв | | | 1 | | | | | | | | 1 | 128.2 |
| 138 | Хэнтий Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | 1 | 0.5 | 1 | 8.0 | 1 | 74.7 |
| 139 | Хэнтий Биндэр нэгдсэн эмнэлэг | | | 1 | | | | | | | | 2 | 36.3 |
| 140 | Хэнтий Зооноз өвчин судлалын төв | | | 1 | | | | | | 1 | 2.8 | 1 | |
| 141 | Хэнтий Уламжлал анагаах ухааны төв | | | 1 | | | | | | | | 1 | 594.1 |
| 142 | Цус сэлбэлт судлалын үндэсний төв | | | | 1 | | | | | 2 | 57.2 | 13 | 702.7 |
| 143 | ЧД-ийн ЭМГ | | | 1 | | | | | | 1 | 8.0 | 4 | 24.6 |
| 144 | Шүд эрүү нүүрний төв | | | | 1 | | | 5 | 4.9 | 8 | 354.2 | 3 | 48.3 |
| 145 | Эмгэг судлалын үндэсний төв | | | 1 | | | | | | | | 4 | 12.9 |
| 146 | ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар | | 1 | | | | | | | | | | |
| 147 | Энэрэл эмнэлэг | | | 1 | | | | | | 1 | 30.0 | 6 | 2.7 |
| 148 | Эрүүл мэндийн хөгжлийн төв | | | 1 | | | | | | 2 | 37.0 | | |
| 149 | Эрүүл мэндийн яам /Аппарат/ | | | | | 1 | | | | 5 | 1,673.4 | 5 | 19,404.3 |
| 150 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | | | | 1 | | | | | 3 | 5.7 | 3 | 476.7 |
| 151 | Эх нярай эмэгтэйчүүдийн хоёр-300 орт | | | | | | | | | | | | |
| | **ДҮН** | **8** | **1** | **117** | **21** | **6** | **1** | **89** | **267.5** | **210** | **24,518.5** | **332** | **33,667.1** |

Хавсралт

## 6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| **1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг** | | | | | |
| 1 | Захирлын 2020 оны №Б/681 тоот тушаалын дагуу 8 дугаар сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтанд ажилласан хугацааны цалинг нөхөн олгохдоо 0.5 сая төгрөгийг илүү бодож олгосон. | 0.5 | Төлбөрийн акт | Ерөнхий нягтлан бодогч<br>Цалингийн нягтлан бодогч | Б.Банзрагч<br>Н.Урансүрэн |
| 2 | Тайлант онд хангамж, засварын материал худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй, харьцуулалтын үнийн арга хэрэглэн 0.1 сая төгрөг, ижил төрлийн, ижил шинж чанар бүхий материалыг тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж 65.3 сая төгрөг, нийт 209.6 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. | 209.6 | Албан шаардлага | ТҮА-аа эрхэлсэн дэд захирал,<br>Захирлын ажлын албаны дарга,<br>Эдийн засагч,<br>ЭХААХТА-ны албаны дарга | Б.Түвшинтөр<br>Ц.Амаржаргал<br>С.Батцэнгэл<br>Г.Баяр |
| **2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг** | | | | | |
| 1 | Багш нарын цалин 21.2 сая төгрөгийн цалин, ажлын хөлсийг НДШ-ийн тайланд тайлагнаагүй, тооцох шимтгэлийг төсөвт төвлөрүүлээгүй. | 5.1 | Төлбөрийн акт | Эмчилгээ эрхэлсэн захирал<br>Ахлах нягтлан бодогч | Ц.Ганзориг<br>А.Байгальсүрэн |
| 2 | Үйл ажиллагааны орлого нийт дүнгээр 896.1 сая төгрөгөөр тасарсан, нэмэлт санхүүжилтээс 4.4 сая төгрөгийг нээсэн эрхийн дагуу зарцуулаагүй. | 900.5 | Албан шаардлага | | |
| 3 | Эрүүл мэндийн даатгалын сангаас орлогыг зардал хэтрүүлсэн, хугацаа хоцроосон, баримтыг буруу бүрдүүлсэн зэрэг шалтгаанаар хасаж санхүүжүүлсэн 41.6 сая төгрөгийг орлого бууруулан бүртгэсэн, хэвтэн эмчлүүлэгсдийн дутуу төлбөрийг аккруэл сууриар бүртгээгүйгээс 3.0 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрөөгүй, авлага үүсгээгүй. | 44.6 | Албан шаардлага | | |
| 7 | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 31 мэдээллээс 24 мэдээллийг байршуулсан бөгөөд гүйцэтгэлийн хувь 53 хувьтай байна. | - | Албан шаардлага | | |
| **58. Говь-Алтай Төгрөг сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Байгууллагын дарга нь өөртөө тушаал шийдвэр гарган 0.2 сая төгрөгийн урамшуулал авсан. | 0.2 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Р.Эрдэнэбаатар Г.Ариунтуяа |
| 2 | Анхан шатны баримтгүй шатах тослох материалын үнэ болох 0.2 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | 0.2 | Төлбөрийн акт | | |
| 3 | Шилэн дансны цахим хуудсанд 27 төрлийн мэдээлэл байршуулахаас 24 мэдээллийг байршуулсан, 4 мэдээллийг мэдээлээгүй. | - | Албан шаардлага | | |
| **59. Говь-Алтай Баян-Уул сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Тушаал шийдвэргүйгээр 0.6 сая төгрөгийн эмийг акталсан байна. | 0.6 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Б.Бат-Эрдэнэ Б.Мөнхзаяа |
| 2 | Цалингийн цэсээс тооцсон тооцоогоор ажиллагсдад олговол зохих 1.1 сая төгрөгийг илүү суутгасан байна. | 1.1 | Төлбөрийн акт | | |
| 3 | Эрчим хүчний сайдын баталсан халаалтын улирлыг хугацааг зөрчин 2.5 т буюу 0.3 сая төгрөгийн нүүрс илүү зарцуулсан байна | 0.3 | Төлбөрийн акт | | |
| 4 | Нягтлан бодогчид шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 1.3 сая төгрөгийг төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй. | 1.3 | Албан шаардлага | | |
| 5 | Дуудлагаар явсан гадны машинд хийсэн 4.9 сая төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй жагсаалтаар олгосон байна. | 4.9 | Албан шаардлага | | |
| 6 | Урсгал засварын материалаас 0.1 сая төгрөгийн шатах тослох материал, Эмийн зардлаас 1.6 сая төгрөгийн нормын хувцас худалдан авсан | 1.7 | Албан шаардлага | | |
| 7 | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 24 мэдээллээс давхардсан тоогоор 13 мэдээллийн 400.7 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд дутуу мэдээлсэн байна. | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Б.Бат-Эрдэнэ Б.Мөнхзаяа |
| **60. Дундговь эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна. | | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Бат-Орших Ч.Бямбаа |
| **61. Дундговь Уламжлалт анагаах ухааны төв** | | | | | |
| 1 | Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон | 0.3 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Х.Чирчинсүрэн Т.Одонцэцэг |
| 2 | Батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй 14.1 сая төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан | 14.1 | Албан шаардлага | | |
| **62. Дундговь Зооноз өвчин судлалын төв** | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд 8 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Б.Алтантөгс Ч.Бямбаа |
| 2 | Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгохдоо авлагын дансанд бичилт хийлгүй цалингийн өглөгийн дансанд бичилт хийсэн. | - | Албан шаардлага | | |
| 3 | Албан томилолтоор ажиллах хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгож, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан. | 0.4 | Албан шаардлага | | |
| **63. Дундговь Говь-Угтаал сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулж идшинд зориулж 2.7 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон. | 2.7 | Албан шаардлага | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Г.Угтахбаяр Б.Батцэнгэл |
| **64. Дундговь Эрдэнэдалай сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй. | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Э.Насандэлгэр У.Хандсүрэн |
| **65. Дорнод Эрүүл мэндийн газар** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тайлант онд нийт 1,48.8 сая төгрөгийн хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлээгүй байна. | 1,482.8 | Албан шаардлага | Дарга | Ч.Оюумаа |
| **66. Дорнод Бүсийн оношилгоо эмчилгээний төв** | | | | | |
| 1 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн зарим зүйл заалтыг мөрдөөгүй | 35.5 | Албан шаардлага | Захирал Нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| 2 | Цалингийн нэмэгдлийг засгийн газрын тогтоол зөрчин олгосон | 68.4 | Албан шаардлага | Захирал Нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| 3 | Жилийн эцсийн тооллогын үр дүнг тайланд тусгаагүй | - | Албан шаардлага | | |
| 4 | Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй | - | Албан шаардлага | | |
| **67. Дорнод Уламжлалт анагаах ухааны төв** | | | | | |
| 1 | Эмийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг хийхдээ төсвийн хэмнэлттэй байх зарчмыг баримтлаагүй, үр дүн багатай гэрээ байгуулж гэрээний үнийг дагаж мөрдөөгүй | 0.9 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Б.Батцэцэг Ц.Мөнхтунгалаг |
| **68. Дорнод Халх гол сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Орлого зарлагын гүйлгээг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй | 101.4 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Д.Алтанзаяа |
| **69. Дорнод Баян-Уул сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй ажилтны цалингаас 0.3 сая төгрөгийн ХХОАТ суутган авсан байна. | 0.3 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Б.Дэлгэрмаа Т.Тунгалагтуяа |
| 2 | Шилэн дансанд байршуулбал зохих 197 мэдээллээс 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан мөн хөрөнгийн 8.4 сая төгрөгийн худалдан авалтыг байршуулаагүй байна. | 8.4 | Албан шаардлага | | |
| 3 | Эмнэлгийн данс бүртгэлд байгаа 25.0 сая төгрөгийн үнэтэй УАЗ фургон 66-19 ДОР, 37.9 сая төгрөгийн үнэтэй УАЗ фургон 03-12 ДОР автомашинуудыг Баян-Уул сумын ЗДТГ-т тушаал шийдвэргүй шилжүүлэн өгсөн байна. | 62.9 | Албан шаардлага | | |
| **70. Дорнод Дашбалбар сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй ажилтны цалингаас 0.1 сая төгрөгийн ХХОАТ суутган авсан байна. | 0.1 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| 2 | Хөрөнгийн орлогыг шилэн дансны мэдээллийн санд байршуулаагүй. | 67.1 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| **71. Дорноговь эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Томилолтын зардлаас цалин хөлс, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлаас хоолны зардал гаргасан. | 3.5 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Энхцэцэг Н.Түмэннаст |
| 2 | Засаг даргын захирамжаар ирсэн санхүүжилтийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан | 1.5 | Албан шаардлага | | |
| **72. Дорноговь нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Олон жил болсон авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч шийдвэрлээгүй | 12.3 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Анхбаяр Ц.Батсайхан |
| **73. Завхан нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Цалин илүү тооцож олгосон | 0.9 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Г.Цогзолмаа Ө.Найдансүрэн |
| **74. Завхан Зооноз судлалын төв** | | | | | |
| 1 | 2020 оны хагас жилийн байдлаар авлагын үлдэгдлийг хангалттай түвшинд бууруулаагүй, өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байхад санхүүгийн ажилтнуудад урамшууллыг илүү тооцож олгосон | 2.2 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Г.Дашдаваа |
| **75. Завхан Тосонцэнгэл сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Хэмнэгдсэн зардлыг НДХ-рүү шилжүүлэн 1.7 сая төгрөгийн авлага үүсгэн тайлагнасан нь | 1.7 | Төлбөрийн акт | Эрхлэгч Нягтлан бодогч | Х.Цэцэгдэлгэр Б.Энхтуяа |
| **76. Завхан Отгонтэнгэр рашаан сувилал** | | | | | |
| 1 | ЭМДС-аас санхүүжилт илүү нэхэмжилж авсан | 10.8 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Д.Цолмон М.Батчулуун |
| 2 | Өөрийн орлогыг дутуу төвлөрүүлсэн | 18.3 | Албан шаардлага | | |
| 3 | Зардлыг буруу тайлагнасан | 3.3 | Албан шаардлага | | |
| **77. Сэлэнгэ Зооноз судлалын төв** | | | | | |
| 1 | 8 албан хаагчид илүү цагийн хөлсийг ажилласан хугацааны цалинтай давхардуулан олгосон. | 0.8 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Н.Эрдэнэбат М.Сэлэнгэ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **78. Сэлэнгэ Мандал сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Сахилгын шийтгэл ногдуулсан эмчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. | 0.3 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Ё.Буяндэлгэр Б.Баярсайхан |
| 2 | Магистрын зэргийн нэмэгдэл олгосон. | 0.6 | Төлбөрийн акт | | |
| 3 | Төсөвт зохицуулалт хийлгээгүй, холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл авалгүйгээр хөрөнгө худалдан авч зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. | 5.5 | Албан шаардлага | | |
| 4 | Аймгийн ЭМГ болон Нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн нийт 36.6 сая төгрөгийн үнэ бүхий 2.5 мянган ширхэг Ковид-19 цар тахлын оношлуур тестийн зарлагын гүйлгээг хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг бүхий зарлагын баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. | 36.6 | Албан шаардлага | | |
| **79. Сэлэнгэ Эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | ЭМЯ-наас нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон эмч ажилтнуудад өгсөн урамшууллын болон илүү цагийн хөлсний хэмнэлтийг жилийн эцэст татан төвлөрүүлснийг 2021 оны илүү цагийн хөлсийг барагдуулна гэх үндэслэлээр тооцоо нийлж баталгаажуулан, авлагаар тайлагнасан. | 33.0 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ж.Од Д.Нямаа |
| 2 | Өмнөх оны интернэтийн төлбөрийг тайлант оны төсвөөс зарцуулсан байна. | 0.5 | Албан шаардлага | | |
| **80. Сэлэнгэ Нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Цалин, нэмэгдлийг илүү тооцож олгосон. | 1.3 | Төлбөрийн акт | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Ц.Эрдэнэчимэг Ц.Энх-Оюун |
| 2 | Анхан шатны бүрдэл дутуу баримтаар шатахууны зардлын гүйлгээ гүйцэтгэж, бүртгэсэн. | 6.3 | Албан шаардлага | | |
| **81. Сэлэнгэ Сайхан сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. | 0.2 | Төлбөрийн акт | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Н.Мөнхтунгалаг Э.Амарзаяа |
| 2 | Төсөвт зохицуулалт хийлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй зардлын бүлэг хооронд нийт 2.2 сая төгрөгийг гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй. | 2.2 | Албан шаардлага | | |
| **82. Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Хандив тусламжийн хөрөнгийг байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд зарцуулсан | 3.5 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Б.Гантулга Ж.Оюунзул |
| 2 | Тооцооллын алдаанаас цалин хөлс, хоолны нөхөн олговрыг илүү бодож олгосон | 0.2 | Төлбөрийн акт | | |
| 3 | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү бодож олгосон | 2.5 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Б.Гантулга Ж.Оюунзул |
| 4 | Анхан шатны баримтаар дэмжигдээгүй ажил гүйлгээг хийж, төсвөөс илүү зардал гаргасан | 0.4 | Төлбөрийн акт | | |
| 5 | Явуулын урьдчилан сэргийлэх үзлэгээр сумдад ажилласан эмч, ажилчдын томилолтын нөхөн олговрыг олгосон боловч Түмэнцогт сумын ЗДТГ-аас хоол, хүнсний материалын үнийг давхардуулан нэхэмжилж авсан. | 0.2 | Төлбөрийн акт | | |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2020 оны 11 дүгээр сард үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. | 0.6 | Албан шаардлага | | |
| 7 | Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй. | 78.5 | Албан шаардлага | | |
| 8 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөв хуваарилах эрх зүйн үр дагавар үүсээгүй байтал хуулиар олгогдоогүй эрх хэмжээгээр сумдын ЭМТ-д төсөв хуваарилсан. | 97.0 | Албан шаардлага | | |
| 9 | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбогдох стандарт, хуулийг мөрдөж ажиллаагүй | 33.8 | Албан шаардлага | | |
| 10 | Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. | - | Албан шаардлага | | |
| **83. Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Цалингийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 24.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй, ХХОАТ-д илүү шилжүүлсэн. | 24.0 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Д.Мөнхзул С.Бямбаа |
| 2 | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 хүнд 1.3 сая төгрөгөөр илүү бодож олгосон, нэр бүхий 7 хүнд 2.1 сая төгрөгийг олгоогүй байна. | 3.4 | Төлбөрийн акт | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Эмийн зардлаас 28.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулжээ | 28.0 | Албан шаардлага | Дарга<br>Нягтлан бодогч | Д.Мөнхзул<br>С.Бямбаа |
| 4 | Эрүүл мэндийн хуудсаар шинээр гэрлэлт батлуулах, ажилд орох, жолооны сургалтад суух иргэдэд төлбөртэй үйлчилгээ үзүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй байна | - | Албан шаардлага | | |
| **84. Сүхбаатар Онгон сум дундын эмнэлэг** | | | | | |
| | Өмнөх санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй | - | Албан шаардлага | Дарга<br>Нягтлан бодогч | Э.Хишигт<br>Э.Оюунжаргал |
| **85. Төв аймгийн эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Хавсран ажилласны нэмэгдлийг 3 хүнд илүү олгосон. | 0.4 | Төлбөрийн акт | Дарга<br>Нягтлан бодогч | С.Мөнхтуяа<br>Б.Төмөрчөдөр |
| 2 | Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн худалдан авалтын гэрээ хугацаа хэтэрсэн, гэрээний нөхцөл хангалтгүй, гэрээ дүгнээгүй. | - | Албан шаардлага | | |
| 3 | Санхүүгийн тайлангаарх 2.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт баримтжуулаагүй, тооцооны нийлсэн актад тооцооны баримтын жагсаалтыг бичээгүй, ХӨСҮТ-тэй тооцоо нийлсэн актын мэдээлэл 6.6 сая төгрөгөөр зөрүүтэй. | 8.7 | Албан шаардлага | | |
| **86. Төв аймгийн нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн гэрээний дүн, нийлүүлэх бараа бүтээгдэхүүний нэр төрөл байхгүй, 10 байгууллагын худалдан авалтыг шалгахад 47.6 сая төгрөгийн гүйлгээг е баримтаар баталгаажуулаагүй. | 47.6 | Албан шаардлага | Дарга<br>Нягтлан бодогч | С.Оюунцэцэг<br>Б.Батболд |
| 2 | 2020 оны батлагдсан орон тоог 18-р хэтрүүлэн ажилласан ба цалин хөлс урамшууллын зардал нь санхүүжилт эх үүсвэрээс шалтгаалан 22.8 сая төгрөгөөр хэмнэсэн. Орон тоо хэтрүүлснээс шалтгаалан үндсэн цалинг 154.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн. | - | Албан шаардлага | | |
| 3 | Засаг даргын захирамжаар ирүүлсэн нүүдлийн амбулаторийн санхүүжилтээс 2.2 сая төгрөгийг дутуу зарцуулсан. | 2.2 | Албан шаардлага | | |
| **87. Орхон эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Байгууллагаас илүү цагийн хөлс бодож олгохдоо 2020 оны 02 сард 31.5 мянга, 2020 оны 06 сард 0.1 сая төгрөгийн илүү цаг ажилласны хөлсийг 2 ажилтанд буруу, илүү тооцоолж олгосон. | 0.1 | Төлбөрийн акт | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,<br>Нягтлан бодогч | Д.Сүхээ<br>Н.Чулуун-Эрдэнэ |
| 2 | Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар үндсэн цалингийн 40% буюу 0.3 сая төгрөгөөр шагнасан, нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 65 тоот төлбөрийн хүсэлтээр Эрүүл мэндийн салбарын ажилчдын В вирусын шинжилгээний төлбөр 4.5 сая төгрөг, нийт 4.8 сая төгрөгийг олгосон. | 4.8 | Албан шаардлага | | |
| 3 | Тус байгууллага нь 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр санхүүгийн тайлан, бусад шаардлагатай харилцахын баримт, материалыг ирүүлэхдээ тээвэр шатахуун, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, байгууллагын нярав нь 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр архивын нэгж болгож үдээгүй задгай, эмх цэгцгүй баримт авчирсан нь аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, албан үүргээ биелүүлээгүй. | 4,735.7 | Албан шаардлага | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,<br>Нягтлан бодогч | Д.Сүхээ<br>Н.Чулуун-Эрдэнэ |
| **88. Орхон нэгдсэн эмнэлэг /Бүсийн оношилгоо, эмчилгээ/** | | | | | |
| 1 | Жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй 2019 онд орон нутгийн болон яамны шагнал авсан ажилтнуудын шагнал урамшууллыг 2020 оны төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 7.1-т “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно” заалттай нийцэхгүй | 0.6 | Төлбөрийн акт | Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал | Б.Батсүх<br>Э.Баасанжаргал |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Тайлант онд 4 удаа томилолтын зардлаас замын шатахуунд 1.2 сая төгрөгийг жолооч, захирал нарт олгосон бөгөөд томилолтоор зарцуулах шатахууныг эхлээд шатахууны картаар хийж томилолт орсны дараа талон авч зарцуулдаг гэх боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. | 1.2 | Албан шаардлага | Захирал, Санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал | Б.Батсүх Э.Баасанжаргал |
| 3 | Хүнсний материалыг зах зээлийн үнээс өндөр үнээр Аз лагшма ХХК-аас 26.2 сая төгрөгөөр худалдан авч бэлтгэсэн. Тухайлбал үхрийн махыг 11000, 10800 төгрөгөөр худалдан авч байхад бусад мах нийлүүлдэг Эрдмийн, Эрдэнэт мах маркетийн махны үнэ 8390, 8500 төгрөг, төмс 1200 төгрөг, лууван 1800 төгрөгөөр худалдан авахад хүнсний ногоо нийлүүлдэг Баясгалант Бат-Очир ХХК-ийн төмсний үнэ 900 төгрөг, лууван 1600 төгрөг байна. | 26.2 | Албан шаардлага | | |
| **89. Увс нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 2-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар нэр бүхий 7 тогоочийн албан тушаалын зэрэглэл буруу тогтоож нийт 1.5 сая төгрөгийн цалинг дутуу олгосон байна. | 1.5 | Төлбөрийн акт | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч | О.Одбаяр Ч.Пүрэвсүрэн |
| **90. Увс Өндөрхангай сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Өндөрхангай сумын засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/34 тоот захирамжаар сумын ЭМТ-н дарга Г.Мөнх-очирт ажил хавсран гүйцэтгэсний цалин 4.1 сая төгрөг олгосон | 4.1 | Албан шаардлага | Засаг дарга | Г.Төмөрчөдөр |
| 2 | Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал дарга Г.Мөнх-Очирт 0.4 сая төгрөг олгосон | 0.4 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Мөнх-Очир С.Сарангэрэл |
| 3 | ЭМТ-ийн даргад мэргэжлээ дээшлүүлэхэд зориулж 0.7 сая төгрөг, 5 албан хаагчийн үндсэн цалин зөрүүтэй тооцож 2.6 сая төгрөгийг дутуу олгосон. | 3.3 | Төлбөрийн акт | | |
| **91. Ховд нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгчдээс бараа, материал худалдан авах гэрээнд тусгай нөхцөлийг оновчтой тодорхойлоогүйгээс хэрэгжилтийг үнэлэх шалгуур тодорхой бус | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Шижир Д.Баярсүрэн |
| 2 | Байгууллагын даргын 2020 оны А/67 дугаар тушаалын дагуу эд хөрөнгийн тооллого хийсэн боловч, хэрэгжүүлсэн ажил хангалтгүй, тасгуудад хандиваар ирсэн зарим эд хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй. | - | Албан шаардлага | | |
| 3 | Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гэрээний үнийн дүнгээс 504.2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд захиалгаар худалдан авсан | 504.2 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Шижир Д.Баярсүрэн |
| 4 | Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүйгээс мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулж, бодит зардлаас 40.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. | 40.5 | Албан шаардлага | | |
| 5 | Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, хэрэглэгчдэд ойлгомжтой байдал хангалтгүй байна. | - | Албан шаардлага | | |
| 6 | Пиөрли тауэр ХХК-аар гүйцэтгүүлсэн нийт 215.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй агааржуулалтын систем суурилуулах ажлаас нийт 3.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал суутган тооцож, төлбөрийг шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэлд холбогдох хяналтуудыг хэрэгжүүлээгүй байна. | 3.7 | Төлбөрийн акт | | |
| **92. Ховд Мөст сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Анхан шатны баримтын бүрдэлгүй, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал, илүү цагийн мөнгө олгосон, нүүрсний үнэ төлсөн боловч орлого авч тайлагнаагүй, нүүрсний үлдэгдэл бодитоор байхгүй, шатахууны тайлан гаргаагүй, үрэлгэн зарцуулсан зарцуулалтыг тайлагнаагүй, олгосноо баталгаажуулаагүй, хувь хүнээс бараа материал, хүнсний материал худалдан авахдаа ашгийн татвар тооцон суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй. | 2.3 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Ж.Пүрэвбаатар С.Ульянов |
| 2 | Жолоочийн тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан, шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг дарга олгодог, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй. | 25.1 | Албан шаардлага | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **93. Ховд Булган сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Эмнэлгийн даргын ажлын үр дүнг дүгнэснийг нотлох баримтгүй, улирлын мөнгөн урамшуулалд 1.2 сая төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон, НАОЛ ХХК-аас ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхой бус 0.6 сая төгрөгийн хүнсний материал, 0.3 сая төгрөгийн хонь худалдан авсан. | 2.1 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Б.Батбаатар А.Нацагбалжинням |
| 2 | 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 236 кг буюу нэг бүрийн үнэ 5700 төгрөгийн үнэтэй 1.3 сая төгрөгийн махны үлдэгдэлтэйгээр тайланд тусгасан 2020 онд зарцуулсныг нотлох баримтгүй, эд хариуцагч нь ажлаас халагдсан ажлаа хүлээлгэн өгөөгүй. | 1.3 | Төлбөрийн акт | | |
| 3 | 2019 оны 9,12 дугаар сард эд хариуцагч нь 108.4 тонн буюу 15.3 сая төгрөгийн нүүрсийг нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, санхүүгийн баримтад байгаа анхан шатны баримтаар нотлогдохгүй,нүүрс нийлүүлэх гэрээ байгуулаагүй, 2019 оны 12 дугаар сард Төрийн банкны түр данснаас эд хариуцагчийн 110200294390 тоот данс руу 11.8 сая төгрөгийг шилжүүлэн бэлнээр авч ямар зардалд зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй. | 27.1 | Төлбөрийн акт | | |
| 4 | Тайлант онд худалдан авсан эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуйн болон түлээ нүүрсний материалын эд хариуцагчийн тайланг сар бүрээр гаргаагүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, эм боох материалын үлдэгдэл зөрүүтэй, оройн ээлжид хонож байгаа ажилчдад хоол хийж өгдөг гэсэн тайлбарыг нягтлан бодогч нь амаар өгч байгаа ч хэдэн ажилтанд хэчнээн нэр төрлийн хэдэн төгрөгийн материал зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй, тайлант онд худалдан авсан зарцуулсан хүнсний материалын тооцоог хийхэд 1.8 сая төгрөгөөр үлдэгдэл зөрүүтэй, эд хариуцагч авч ажиллуулаагүй. | 440.7 | Албан шаардлага | | |
| 5 | 2019-2020 оны нүүрсний зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад санхүүгийн тайлан дахь нүүрсний үлдэгдлээс 80.8 сая төгрөгийн нүүрс бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтууд бүрэн бус учир зарцуулалтыг хянах боломжгүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй Байтаг цагаан бургаст ХХК, Минж төгөл ХХК нь 2019, 2020 онуудад тус байгууллагад нүүрсийг бүрэн нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, анхан шатны баримтуудаар бүрэн нотлогдохгүй. | 80.8 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Б.Батбаатар А.Нацагбалжинням |
| 6 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг цахим сайтад байршуулаагүй зөрчил илэрлээ. | - | Албан шаардлага | | |
| **94. Хэнтий Эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Өмнөх оны аудитаар буруутай шийдвэр гаргасан ажилтнаар төлүүлэхээр тавигдсан төлбөрийн актыг төсвөөс төлж барагдуулсан холбогдох ажилтнаас суутган тооцоогүй. | 1.1 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Л.Мэндбаяр М.Дагва |
| 2 | Цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 2.3 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн | 2.3 | Албан шаардлага | | |
| 3 | Үндсэн хөрөнгийн үлдэгдлээс түүвэрлэн хяналтын тооллого хийхэд 12.1 сая төгрөгийн 7 ширхэг суурин компьютер биетээр байхгүй сумын ЭМТ-үүдэд ашиглуулж байна | 12.1 | Албан шаардлага | | |
| **95. Хэнтий нэгдсэн эмнэлэг** | | | | | |
| 1 | Хавсран ажилласны нэмэгдлийг анхан шатны баримтаас 1.1 сая төгрөгийг зөрүүтэй тооцож олгосон. | 1.1 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Д.Оюунгэрэл Д.Өсөхгэрэл |
| 2 | Цалингийн зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 24.6 сая төгрөгийн ажиллагсдаас төлөх НДШ-ийг байгууллагаас төлсөн. | 24.6 | Албан шаардлага | | |
| **96. Хэнтий Бор-Өндөр сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Замын хуудсыг түүвэрлэн шатахууны зарцуулалтыг шалгахад 1, 2 дугаар сард зарцуулбал зохих нормоос 0.5 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан. | 0.5 | Төлбөрийн акт | Дарга | А.Батбаатар |
| 2 | Эдийн засгийн ангилал зөрүүлэн 8.0 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан. | 8.0 | Албан шаардлага | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **97. Хэнтий Зооноз өвчин судлалын төв** | | | | | |
| 1 | Цалингийн зардлаас төлөх НДШ-ийн 2.8 сая төгрөгийг төлж төсвийг зориулалт бус зарцуулсан. | 2.8 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Г.Наранхүү Л.Цогтцэцэг |
| **98. Өвөрхангай Эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Жолоочийн анхан шатны баримт болох тооцооны хуудасгүй 16.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан. | 16.2 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Д.Шивааннүрдэв Б.Валя |
| 2 | Урьд оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 170.0 сая төгрөгийн зөрчилтэй холбоотой зөвлөмжийг биелүүлээгүй. | 170.0 | Албан шаардлага | | |
| 3 | Төсвийн зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулж урсгал санхүүжилтээс 10.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. | 10.0 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Д.Шивааннүрдэв Б.Валя |
| 4 | Шилэн дансны цахим хуудсанд 282.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбогдон гарсан тушаал шийдвэр байршуулаагүй. | 282.0 | Албан шаардлага | | |
| **99. Өвөрхангай Бүсийн оношилгоо эмчилгээний төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 11 мэдээлэл хугацаа хоцорсон, хөрөнгө мөнгө зарцуулах тухай 5 тушаал шийдвэрийг мэдээлээгүй. | 55.0 | Албан шаардлага | Захирал Нягтлан бодогч | Э.Хүдэрчулуун Г.Ганчөдөр |
| 2 | Хоолны зардлаас байгууллагын ахмадууд хүлээ авах арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан. | 1.0 | Албан шаардлага | | |
| **100. Өвөрхангай Хархорин сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Тогтмол зардал болон шатахууны зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс авлага үүсгэсэн | 8.8 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Л.Ууганбаяр Д.Мандах |
| 2 | Төсвийн зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулснаас урсгал зардлын санхүүжилтээр үндсэн хөрөнгө бэлтгэсэн. | 6.2 | Албан шаардлага | | |
| 3 | Шилэн дансны сайтад 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, хөрөнгө зарцуулалттай холбоотой 6 шийдвэр, хөрөнгийн зардал, худалдан авалттай холбоотой мэдээллийг байршуулаагүй. | 121.0 | Албан шаардлага | | |
| **101. Өвөрхангай Есөнзүйл сум дундын эмнэлэг** | | | | | |
| 1 | Эм ханган нийлүүлэгчээс авсан эмийн 5.4 сая төгрөгийн үндсэн баримтуудыг эд хариуцагчийн тайланд хавсаргаагүй. | 5.4 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ж.Хоролсүрэн Б.Гүррагчаа |
| 2 | Эд хариуцагчийн тайланг батлагдсан маягтаар гаргаагүй, эмийн тайланд туссан орлого 11.6 сая төгрөгөөр дутуу, зарлага 1.0 сая төгрөгөөр илүү тусгагдсанаас үлдэгдэл таараагүй. | 12.6 | Албан шаардлага | | |
| 3 | Шилэн дансны сайтад 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгө зарцуулалтай холбоотой 5 шийдвэрийг сайтад байршуулаагүй, 18.4 сая төгрөгийн зарцуулалтыг мэдээлээгүй. | 18.4 | Албан шаардлага | | |
| 4 | Тусгай зориулалтын материал 28.0 сая, аж ахуйн материал 6.5 сая төгрөгийн бараа материалыг тоолоогүй. Тооллогын комисс нь тайлан илтгэх хуудас бичээгүй. Нягтлан бодогч тооцоо бодоогүй. | 34.5 | Албан шаардлага | | |
| **102. Өмнөговь Бүсийн оношилгоо эмчилгээний төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд 26 мэдээлэл хугацаа хоцроосон. | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ц.Өнөржаргал Б.Мөнхгэрэл |
| 2 | Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш 18 гүйлгээ бүртгээгүй. | 40.3 | Албан шаардлага | | |
| 3 | ХХОАТ авлагатай тайлагнасан. Тооцоо нийлсэн акт үйлдээгүй. | 8.0 | Албан шаардлага | | |
| 4 | НДШ-ийг 8.4 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан. | 8.4 | Албан шаардлага | | |
| 5 | Жилийн эцэст эм ханган нийлүүлсэн харилцагчидтай тооцоо нийлээгүй, бараа материалын орлогын журнал, и-баримт, харилцахын зарлага зөрүүтэй тайлагнасан. | 59.2 | Албан шаардлага | | |
| 6 | ЭМЯ, аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, бараа материалд тооцоо нийлээгүй байна. | 588.8 | Албан шаардлага | | |
| **103. Өмнөговь эрүүл мэндийн газар** | | | | | |
| 1 | Жолоочийн тооцоог жишиг нормтой тулган баталгаажуулахад 1738.3 литр буюу 2.6 сая төгрөгийн шатахуун илүү олгосон. | 2.6 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Т.Оюундүү Ш.Баттогтох |
| **104. Өмнөговь Зооноз судлалын төв** | | | | | |
| | Санхүүгийн тайланд байгууллагаас авах авлага 4.0 сая төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 3.6 сая төгрөг байна. | 7.6 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Д.Алтанчимэг Ш.Түмэнцэцэг |
| **105. Өмнөговь Ноён эрүүл мэндийн төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим сайтад 35 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ц.Бурмаа А.Бямбажаргал |
| | **Дүн** | **24,786.0** | | | |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 589/А011000 1 Улаанбаатар хот

САГ-2021/11 ІСТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн 212.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох ангиллын дагуу залруулан бүртгэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, харьяа 26 байгууллага 37.3 сая төгрөгийн хөрөнгийг залруулж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн салбарын эдийн засаг бодлого хэрэгжилтийн газрын дарга Д.Нарантуяа, Ерөнхий нягтлан бодогч О.Бурмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,*
*Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar45.Docx

001081388

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 04 дугаар сарын 26 № 590/А0110001 Улаанбаатар хот

САГ-2021/11/СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах (MON-8) төслийн 124,098.7 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын тушаал шийдвэргүй Улсын хоёрдугаар төв эмнэлэгт шилжүүлж ашиглуулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэж заасантай нийцэхгүй, мөн санхүүгийн тайлангийн “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн салбарын эдийн засаг бодлого хэрэгжилтийн газрын дарга Д.Нарантуяа, Ерөнхий нягтлан бодогч О.Бурмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,*
*Утас 51-264230*

*\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar46.Docx*

001081391

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 591/А0110001 Улаанбаатар хот

САГ-2021/11/СТА-ТЕЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Эрүүл мэндийн яам, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг, Булган аймгийн Хишиг-Өндөр сум дундын эмнэлэг зэрэг 6 байгууллага сөрөг дүгнэлт авсан, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.2-т “төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх байгууллагуудын төсвийн захирагч нарт хуульд заасны дагуу арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн салбарын эдийн засаг бодлого хэрэгжилтийн газрын дарга Д.Нарантуяа, Ерөнхий нягтлан бодогч О.Бурмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,*
*Утас 51-264230*

*\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar47.Docx*

001081394